**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН**
**ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 12 өдөр Дугаар А/07 Баянхутаг сум

# ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Улсын хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тушаал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 27.1.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Сумын хэмжээнд ой, хээрийн гал түймрийн эрсдлийг тодорхойлох, баг, малчин иргэдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулах, малчин иргэдийн байршил /координат/-ыг тодорхойлох, иргэдээс ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр судлагаа гаргаж авах, сум, багийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга, байгуулгын дарга нарт үүрэг болгосугай.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангахад гарах зардлыг хавсралтаар батлсугай.

Дээр дурьдсан арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг эрсдлийн сангаас гаргахыг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч /Д.Баярмаа/-д зөвшөөрсүгэй

ДАРГА Г.БОЛД

Баянхутаг сумын Засаг даргын
тамгын газрын 2025 оны 09 дугаар
сарын 12 –ны өдрийн А/07 дугаар
Тушаалын хавсралт

Хөрөнгийн зарцуулалтын задаргаа

| дд | Барааны нэр | Үнэ |
|---|---|---|
| 1 | Шатахуун | 1,000,000 |
| 2 | Бичиг хэргийн зардал | 375,000 |
| | Нийт | 1,375,000 |

БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.БОЛД
оны.../...дугээр тушаалын хавсралт

УДИРДАМЖ

2025 оны 03 дугаар сарын 12 Баянхутаг сум

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх,
Тэмцэх арга хэмжээний тухай

*Нэг. Зорилго*

Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, орон нутгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг төлөвлөх, хамтын ажиллагааг зохицуулах, ой хээрийн гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, удирдлага зохицуулалтаар хангах, нөөц хангалтын зохион байгуулах, гал түймэр гарсан тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлох, багийн малчдын хаваржилтын байдал, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж бэлтгэл бэлэн байдлыг хэрхэн ханган ажиллахад оршино.

*Хоёр. Хугацаа*: 2025 оны 03 дугаар сарын 12-13

*Гурав. Хамрах хүрээ хугацаа*: Цантын хоолой баг, Улаан-Өндөр баг, Жаргалант баг.

3.1. Удирдамжийн хэрэгжилтийг Сумын онцгой комиссын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, шуурхай штаб нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.2. Удирдамжийг 2025 онд хэрэгжүүлж ажиллана.

*Дөрөв*. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, судалгаа авах, зөвлөмж өгөх удирдан явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Цантын хоолой баг: Б.Алтангэрэл
Л.Энхцэцэг
С.Алимаа

Улаан-Өндөр баг: Д.Алтанчимэг
А.Чимэддондов
Б.Баярмагнай

Жаргалант баг: Д.Буянбат
Д.Норов-Эрдэнэ
Б.Батцоож

*Тав. Гамшгаас хамгаалах судлагаа авах, зөвлөмж зөвлөгөө өгөх ажлын чиглэл*

5.1. Хавар, намрын хуурайшилттай үед цогтой үнс нурмаа битүү тагтай саванд хийх

5.2. Тамхи, чүдэнзний галыг унтраалгүй ил задгай хаяхгүй байх

5.3. Дуусан гал асаагуурыг хээр хөдөө ил задгай хаяхгүй байх

5.4. Ой, хээрт явахдаа яндангийн оч баригчгүй машин техникээр зорчихгүй байх

5.5. Түймрийн аюултай үед гэр, байшин, майхан, малын хашаа, саравч, өвс тэжээл, худгийн эргэн тойронд 100-гаас доошгүй метрийн өргөнтэй цурав татах, шороон зурвас гаргах

5.6. Насанд хүрээгүй хүүхдийг шүдэнз, асаагуураас хол байлгах

5.7. Шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэж, өөрийнхөө болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг ой, хээрийн түймэрт өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхийг анхааруулж байна.

5.8. Ой хээрийн түймрийн эрсдлийг тодорхойлох

5.9. Багийн малчин иргэдийг нүүлгэн шилжүүлж, төлөвлөгөө боловсруулах.

5.10. Малчин иргэдийн байршил координатыг тодорхойлох.

5.11. Иргэдээс ой хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр судалгаа гаргаж авах.

5.12. Бусад цаг үеийн ажилаар малчдад мэдээлэл өгөх

*Зургаа:* Ажлын хэсгийн бүрэлдэхүүн тайланг бичиж өгөх.

| | |
|---|---|
| УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: | ХЯНАСАН: |
| АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН | ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН |
| ЭРХЛЭГЧ М.ЭНХБАЯР | МЭРГЭЖИЛТЭН Б.ЭНХТУУЛ |

ХЭНТИЙ АЙМАГ
ОНЦГОЙ КОМИСС

Чингис хот, Хэнтий аймаг, 23000
Утас/Факс: 70-56-22-24
E-mail: infoezdig@khentii.gov.mn

2025.03.07 № 06

танай ____________-ны №____________-т

СУМ, ТОСГОДЫН ЗАСАГ ДАРГА,
ЗАХИРАГЧ НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тушаал "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө", Улсын онцгой комиссын даргын 2025 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус гаргаж орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын онцгой комиссоос ирүүлсэн Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээгээр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Хэрлэн, Бор-Өндөр, Биндэр, Дадал, Дархан Норовлин зэрэг 8 сум өндөр, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Галшар, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Бор-Өндөр зэрэг 11 сум ой, хээрийн гал түймэрт өртөх маш өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Иймд сумын хэмжээнд ой, хээрийн гал түймрийн эрсдэлийг тодорхойлох, баг, малчин иргэдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулах, малчин иргэдийн байршил /координат/-ыг тодорхойлох, иргэдээс ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр судалгаа гаргаж авах, сум, тосгоны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж бэлэн байдлыг ханган 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Онцгой байдлын газрын егр ирүүлнэ үү.

Жич: Хавсралтаар ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ, судалгааны маягтыг хүргүүлэв.

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЭРДЭНЭБАТ

АТА-4639

D:/my doc/toot-2025/A-4/doc

# ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ АЙЛ ӨРХИЙН СУДАЛГАА

Сумын нэр ..............................

| № | Овог, нэр | Ам бүлийн тоо | Баг | Сумын төвөөс алслагдсан зай /км/ | Газар орны нэр | Байршил /коэрдинат/ | Туулах чадвартай автомашины тоо | Гал түймэртэй тэмцэх чадвартай иргэний тоо | Бага насны хүүхдийн тоо | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо | Өндөр настай иргэний тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |

УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

[illegible]

2025.02.17 № 36

танай ______ -ны № ______ -т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Улсын онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тушаал "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө", Улсын онцгой комиссын даргын 2025 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг тус тус батлуулж, төв, орон нутгийн Онцгой комиссын дарга, Онцгой байдлын байгууллагад хүргүүлсэн.

Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээгээр нийслэлийн 7 дүүрэг өндөр, 2 дүүрэг маш өндөр, Дорнод аймгийн 14 сум маш өндөр, Сүхбаатар аймгийн 8 сум өндөр, 5 сум маш өндөр, Хэнтий аймгийн 7 сум өндөр, 11 сум маш өндөр, Төв аймгийн 19 сум өндөр, Говьсүмбэр аймгийн 2 сум өндөр, Сэлэнгэ аймгийн 13 сум өндөр, 4 сум маш өндөр, Дорноговь аймгийн 2 сум өндөр, Дархан-Уул аймгийн 3 сум өндөр, 1 сум маш өндөр, Булган аймгийн 8 сум өндөр, 4 сум маш өндөр, Архангай аймгийн 4 сум өндөр, 7 сум маш өндөр, Хөвсгөл аймгийн 13 сум өндөр, 5 сум маш өндөр, Завхан аймгийн 5 сум өндөр, Баян-Өлгий аймгийн 1 сум өндөр, Увс аймгийн 6 сум ой, хээрийн гал түймэрт өртөх эрсдэл өндөр байна.

Иймд ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээгээр ой, хээрийн гал түймэрт өртөх эрсдэл өндөр бүсэд байрлах сум, дүүргийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийг хийж баталгаажуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Жич: Хавсралтаар ой, хээрийн гал түймэрт өртөх эрсдэл өндөр, маш өндөр сум, дүүргийн холбогдох мэдээллийг хүргүүлэв.

ОРЛОГЧ ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

## 1. Улсын хэмжээнд баг, хорооны түвшинд ой, хээрийн гал түймэрт өртөж болзошгүй байдал

Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн түймрийн өртөх байдлыг тодорхойлоход нийт 1809 баг, хорооны 48.9 хувь нь өртөх байдал дунд, өндөр, маш өндөр түвшин (дунд 15,4%, өндөр 25,8, маш өндөр 7,8%)-д тодорхойлогдсон байна.

Аймаг тус бүрээр ой, хээрийн түймэрт өртөх байдлыг сумдаар авч үзэхэд Дорнод аймгийн 14 сум маш өндөр, Сүхбаатар аймгийн 12 сум өндөр, 1 сум маш өндөр, Хэнтий аймгийн 3 сум маш өндөр, 13 сум өндөр, 2 сум дунд. Төв аймгийн 17 сум маш өндөр, 4 сум дунд, Говьсүмбэр аймгийн 2 сум өндөр, Сэлэнгэ аймгийн 4 сум маш өндөр, 8 сум өндөр, 2 сум дунд. Дорноговь аймгийн 2 сум дунд, Дархан-Уул аймгийн 3 сум өндөр, Булган аймгийн 1 сум маш өндөр, 8 сум өндөр, 7 сум дунд, Архангай аймгийн 2 сум маш өндөр, 6 сум өндөр, 8 сум дунд, Хөвсгөл аймгийн 1 сум маш өндөр, 10 сум өндөр, 10 сум дунд, Завхан аймгийн 1 сум өндөр, 13 сум дунд, Увс аймгийн 1 сум өндөр, 7 сум дунд түвшинд тодорхойлогдсон байна. Мөн Улаанбаатар хотын хэмжээнд 2 дүүрэг маш өндөр, 5 дүүрэг өндөр (үүний 4 дүүргийн нийт хорооны 50%-аас дээш нь өндөр), 2 дүүрэг бага түвшинд тус тус үнэлэгдсэн байна.

### 1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ой, хээрийн гал түймэрт өртөх байдлын түвшин (баг, хорооны тоо, ээлэх хувь (%)-аар)

| Аймаг | Сум | | Ой, хээрийн түймэрт өртөж болзошгүй баг/хорооны тоо | | | | | Нийт баг/ хорооны тоо | Ой, хээрийн түймэрт өртөж болзошгүй баг/хорооны эзлэх хувь (%) | | | | | Нийт % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Маш бага | Бага | Дунд | Өндөр | Маш өндөр | | Маш бага | Бага | Дун д | Өндөр | Маш өндөр | |
| Улаанбаатар | Багануур | 28570 | | | | | 5 | 5 | | | | | 100 | 100 |
| Улаанбаатар | Багахангай | 4123 | | | | | 2 | 2 | | | | | 100 | 100 |
| Улаанбаатар | Баянгол | 242844 | 20 | | | 5 | | 25 | 80 | | | 20 | | 100 |
| Улаанбаатар | Баянзүрх | 361689 | 16 | | | 12 | | 28 | 57.1 | | | 42.9 | | 100 |
| Улаанбаатар | Налайх | 37659 | | | | 8 | | 8 | | | | 100 | | 100 |
| Улаанбаатар | Сонгинохайрхан | 327580 | 10 | | | 33 | | 43 | 23.3 | | | 76.7 | | 100 |
| Улаанбаатар | Сүхбаатар | 144409 | 8 | | | 12 | | 20 | 40 | | | 60 | | 100 |
| Улаанбаатар | Хан-Уул | 187278 | 6 | | 1 | 14 | | 21 | 28.6 | | 4.8 | 66.7 | | 100 |
| Улаанбаатар | Чингэлтэй | 148977 | 6 | | | 13 | | 19 | 31.6 | | | 68.4 | | 100 |
| Дорнод | Хэрлэн | 46221 | 1 | | | | 10 | 11 | 9.1 | | | | 90.9 | 100 |
| Дорнод | Баяндун | 3094 | 2 | | | 1 | 1 | 4 | 50 | | | 25 | 25 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дорнод | Баянтүмэн | 2498 | 1 | | | | 3 | 4 | 25 | | | |
| Дорнод | Баян-Уул | 4664 | 3 | | | 1 | 2 | 6 | 50 | | | 16.7 |
| Дорнод | Булган | 1968 | | | | 2 | 2 | 4 | | | | 50 |
| Дорнод | Гурванзагал | 1439 | | | | | 3 | 3 | | | | |
| Дорнод | Дашбалбар | 3433 | 1 | | | 2 | 2 | 5 | 20 | | | 40 |
| Дорнод | Матад | 3296 | | | | 1 | 5 | 6 | | | | 16.7 |
| Дорнод | Сэргэлэн | 1990 | 1 | | | 1 | 3 | 5 | 20 | | | 20 |
| Дорнод | Халхгол | 3334 | 1 | | | 1 | 1 | 3 | 33.3 | | | 33.3 |
| Дорнод | Хөлөнбуйр | 1868 | | | | 2 | 1 | 3 | | | | 66.7 |
| Дорнод | Цагаан-Овоо | 3710 | 2 | | | 1 | 3 | 6 | 33.3 | | | 16.7 |
| Дорнод | Чойбалсан | 2676 | | | | | 4 | 4 | | | | |
| Дорнод | Чулуунхороот | 1829 | 1 | | | | 2 | 3 | 33.3 | | | |
| Сүхбаатар | Баруун-Урт | 21852 | | | | 9 | | 9 | | | | 100 |
| Сүхбаатар | Асгат | 1878 | | | | 3 | 1 | 4 | | | | 75 |
| Сүхбаатар | Баяндэлгэр | 5046 | 1 | 1 | | 4 | | 6 | 16.7 | 16.7 | | 66.7 |
| Сүхбаатар | Дарьганга | 3079 | | | | 3 | 1 | 4 | | | | 75 |
| Сүхбаатар | Мөнххаан | 4845 | | | | 4 | 1 | 5 | | | | 80 |
| Сүхбаатар | Наран | 1637 | | | | 3 | | 3 | | | | 100 |
| Сүхбаатар | Онгон | 3824 | 2 | | | 3 | | 5 | 40 | | | 60 |
| Сүхбаатар | Сүхбаатар | 3393 | | | | 4 | 1 | 5 | | | | 80 |
| Сүхбаатар | Түвшинширээ | 3384 | | | | 5 | | 5 | | | | 100 |
| Сүхбаатар | Түмэнцогт | 2486 | 1 | | 2 | | 1 | 4 | 25 | | 50 | |
| Сүхбаатар | Уулбаян | 2941 | 1 | | | 4 | | 5 | 20 | | | 80 |
| Сүхбаатар | Халзан | 1751 | | | | 4 | | 4 | | | | 100 |
| Сүхбаатар | Эрдэнэцагаан | 6768 | | | | 3 | 5 | 8 | | | | 37.5 |
| Хэнтий | Хэрлэн | 23765 | | | | 1 | 7 | 8 | | | | 12.5 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэнтий | Баян-Овоо | 1894 | | | 2 | 2 | | 4 | | | 50 | 50 | | 100 |
| Хэнтий | Баянхутаг | 2424 | | | | 3 | | 3 | | | | 100 | | 100 |
| Хэнтий | Биндэр | 4034 | 2 | | | 1 | 2 | 5 | 40 | | | 20 | 40 | 100 |
| Хэнтий | Галшар | 2179 | | 2 | 1 | 3 | | 6 | | 33.3 | 16.7 | 50 | | 100 |
| Хэнтий | Дадал | 3057 | | | | 2 | 2 | 4 | | | | 50 | 50 | 100 |
| Хэнтий | Дархан | 1920 | | | 2 | | 2 | 4 | | | 50 | | 50 | 100 |
| Хэнтий | Дэлгэрхаан | 2497 | | | | 5 | | 5 | | | | 100 | | 100 |
| Хэнтий | Жаргалтхаан | 2232 | | | | 4 | 1 | 5 | | | | 80 | 20 | 100 |
| Хэнтий | Мөрөн | 1868 | | | | 5 | | 5 | | | | 100 | | 100 |
| Хэнтий | Норовлин | 2596 | | | | | 4 | 4 | | | | | 100 | 100 |
| Хэнтий | Өмнөдэлгэр | 5851 | | | | 4 | 3 | 7 | | | | 57.1 | 42.9 | 100 |
| Хэнтий | Цэнхэрмандал | 2073 | 1 | | | 2 | 1 | 4 | 25 | | | 50 | 25 | 100 |
| Хэнтий | Бор-Өндөр | 8838 | | | | 6 | | 6 | | | | 100 | | 100 |
| Төв | Зуунмод | 16677 | | | | 6 | | 6 | | | | 100 | | 100 |
| Төв | Алтанбулаг | 1529 | | | | 2 | | 2 | | | | 100 | | 100 |
| Төв | Архуст | 1327 | | | | 2 | | 2 | | | | 100 | | 100 |
| Төв | Батсүмбэр | 6861 | 3 | | | 1 | | 4 | 75 | | | 25 | | 100 |
| Төв | Баяндэлгэр | 1564 | | | | 2 | | 2 | | | | 100 | | 100 |
| Төв | Баянжаргалан | 1631 | | 1 | | 2 | | 3 | | 33.3 | | 66.7 | | 100 |
| Төв | Баяндалай | 1367 | | | | 2 | | 2 | | | | 100 | | 100 |
| Төв | Баянцогт | 1691 | | | | 3 | | 3 | | | | 100 | | 100 |
| Төв | Баянчандмань | 4175 | | | | 3 | | 3 | | | | 100 | | 100 |
| Төв | Борнуур | 4902 | | | | 4 | | 4 | | | | 100 | | 100 |
| Төв | Жаргалант | 6568 | | | | 4 | | 4 | | | | 100 | | 100 |
| Төв | Заамар | 5804 | | | | 4 | | 4 | | | | 100 | | 100 |
| Төв | Лүн | 2501 | | | 2 | 1 | | 3 | | | 66.7 | 33.3 | | 100 |
| Төв | Мөнгөнморьт | 2211 | | | | 3 | | 3 | | | | 100 | | 100 |
| Төв | Сүмбэр | 1748 | | | | 2 | | 2 | | | | 100 | | 100 |
| Төв | Сэргэлэн | 2013 | | | | 5 | | 5 | | | | 100 | | 100 |
| Төв | Угтаал | 2595 | | | | 3 | | 3 | | | | 100 | | 100 |